

ШҮҮЛТ, ШУДАРГА ЁС БУРХАНЫ ХАЙР

29 ЭЦГИЙН ХАЙР

Байгаль дэлхий нь Бурханы хайр, хүч болон алдар сууг үргэлж харуулдаг. Байгаль нь Бүтээлийн цагаас эхлэн байгаль нь Бүтээгч Бурханы тушаалыг дагаж ирсэн. Тэрхүү Үг- тушаалд дуулгавартай байдал Түүний ивээлүүдийг нээж өгдөг. Дайсныг ялсан ялалт бий болох хүртэл амар амгалан оршихгүй болно. Түүний Үгийг дуулгавартай дагаснаар ирэх ялалтаар тань дамжуулан таныг болон бусдыг ивээхийг Бурхан хүсдэг.

Сатан бол таныг хараалынхаа суваг болгохыг хүсдэг. Сатан таныг Бурханы тушаалууд болон зааврыг умартаж аливааг өөрийнхөөрөө үйлдэхэд (баруун эсвэл зүүн тийш хазайж) хүргэдэг. Бурханы Үгийг үл дагаснаар Сатан таныг өөрийн эрхшээлд оруулдаг.

¹⁸Бурханы уур хилэн үнэнийг зөвт бусаар нуун дарагч хүмүүсийн аливаа бурханлаг бус ба зөвт бус байдлын эсрэг тэнгэрээс илчлэгддэг. ¹⁹Учир нь Бурханы тухай мэдэж болох зүйл тэдний дунд илэрхий байдаг юм. Учир нь Бурхан тэдэнд ил болгосон аж. ²⁰Ертөнц бүтээгдсэнээс хойш Түүний үл үзэгдэх чанарууд, Түүний мөнх хүч ба бурханлаг төрх нь бүтээгдсэн зүйлсээр дамжуулан ойлгогдон, илэрхий харагдаж байгаа. Иймээс тэдэнд шалтаг байхгүй. ²¹Яагаад гэвэл тэд Бурханыг мэдсэн атлаа Бурхан хэмээн Түүнийг алдаршуулсан ч үгүй, Түүнд талархал өргөсөн ч үгүй. Харин тэд бодол санаандаа хоосорч, мунхаг зүрх сэтгэл нь харанхуй болжээ. ²²Мэргэн гэж хэлдэг атлаа тэд мунхаг болсон бөгөөд ²³үл муудагч Бурханы алдрыг мууддаг хүн, шувууд, дөрвөн хөлт амьтад хийгээд мөлхөгчидтэй адил дүрээр сольжээ.

²⁴Иймээс Бурхан тэднийг зүрх сэтгэлийнх нь хүсэл тачаалын бузар юмстай нь зөнд нь орхиж, тэднийг өөрсдийнхөө махан биеийг гутаахад хүргэжээ. ²⁵Яагаад гэвэл, тэд Бурханы үнэнийг худал хуурмагаар сольж, Бүтээгчээс илүү бүтээлд нь мөргөн, зарагджээ. Бурхан бол үүрд магтагдах Бүтээгч мөн. Амен. (Ром 1:18-25 АБ 2004)

Бурханы тушаалыг сахидаг хүмүүс болон Есүсийн гэрчлэлийг хүлээн авдаг хүмүүсийн эсрэг дайтдаг дайсан хэн болохыг Үг илчилдэг.

¹⁷Луу мөнөөх эмэгтэйд хилэгнэж, Бурханы хуулиудыг болон Есүсийн гэрчлэлийг сахидаг, эмэгтэйн бусад үр удамтай нь дайтахаар явав. (Илчлэлт 12:17 АБ 2004)

Есүс " энэ нь бичигдсэн" Үгээр ялж дуулгавартай байснаараа "Үхлийн хүчийг залгисан". Гэхдээ, үхэл хараахан устгагдаагүй байна.

²⁴Тэр бүх удирдлага, эрх мэдэл, хүчийг хүчингүй болгон, Бурхан ба Эцэгт хаанчлалыг тушаах үед төгсгөл ирнэ. ²⁵Учир нь Тэр бүх дайснуудаа Өөрийн хөл дороо оруулах хүртэл ноёрхох ёстой. ²⁶Эцэст нь устгагдах дайсан бол үхэл мөн. (1 Кор 15:24-26 АБ 2004)

Есүсийн энэ дэлхий дэхь ажил хараахан дуусаагүй байна. Энэ нь Түүний сонгосон нэгэн, Бурханд итгэдэг, дуулгавартай хүүхдүүдээр дамжуулан үргэлжилдэг.

⁵⁴Энэхүү муудах нь үл муудахыг өмсөж, энэ үхлийн бие нь үхэшгүйг өмсөх үед “Үхэл ялалтад залгигдсан” гэж бичигдсэн үг биелнэ. ⁵⁵“Үхэл ээ, чиний ялалт хаана байна вэ? Үхэл ээ, чиний хатгуур хаана байна вэ?” ⁵⁶Үхлийн хатгуур нь нүгэл. Нүглийн хүч нь хууль юм. ⁵⁷Харин бидний Эзэн Есүс Христээр бидэнд ялалтыг өгдөг Бурханд талархал нь байх болтугай. ⁵⁸Тиймээс хайрт ах дүү нар минь, та нарын нөр их хөдөлмөр Эзэн дотор хоосон зүйл биш гэдгийг мэдэж, тууштай байж, гуйвж дайвалгүй, Эзэний үйл хэрэгт үргэлж бялхсан бай. (2 Кор 6:2 АБ 2004)

²Учир нь Тэр“Би тааламжтай цагт чамайг сонссон. Авралын өдөрт Би чамд тусалсан” ¹⁰Тэр надад ингэж хэлэв. -Энэхүү номын эш үзүүлэгийн үгсийг бүү лацад. Учир нь цаг ойрхон байна. ¹¹Бурууг үйлддэг нэгэн нь буруугаа үйлдсээр л байг. Бузар муу нэгэн нь бузар муу чигээрээ л байг. Зөвт нэгэн нь зөвт байдлаа хэрэгжүүлсээр л байг. Ариун нэгэн нь өөрийгөө ариунаар сахисаар л

байг.¹²Харагтун, Би удахгүй ирнэ. Хүн бүрд үйлдсэнийх нь дагуу буцаан төлөхийн тулд Миний шагнал Надтай хамт байгаа.

¹³Би бол Альфа ба Омега, Эхэн ба Эцэс, Эхлэл ба Төгсгөл мөн.

¹⁴Амийн мод уруу очих эрхтэй болохын тулд болон хаалгаар хот уруу орохын тулд дээлээ угаагчид нь ерөөлтэй еэ!

¹⁵Гадна талд нь ноход, мэргэ төлөгчид, завхай хүмүүс, алуурчид, шүтээнд мөргөгчид болоод худлыг хайрладаг, үйлддэг бүхэн байна.¹⁶Есүс Би чуулгануудын төлөө та нарт эдгээр зүйлийг гэрчлэхийн тулд Өөрийн тэнгэр элчийг илгээлээ. Би бол Давидын Удам ба Үндэс, гэрэлт үүрийн цолмон билээ гэв. (Илчлэлт 22:10-16 АБ 2004)

[] Та " нигүүлслийн цаг хугацааны" ач холбогдлыг мэдэх үү "

[] Та хаана хамаатайгаа мэдэх үү?

29.1 АДАМ БА ЭВА

²⁰Хүн эхнэрээ Ева гэж нэрлэжээ. Учир нь тэр амьд бүхний эх болсон ажээ. ²¹ЭЗЭН Бурхан Адам ба түүний эхнэрт зориулж, арьсан дээл хийж өмсгөжээ. (Эхлэл 3:20-21 АБ 2004)

[] Та нүглээ хаацайлахын тулд бусдад хамааруулдаг уу?

[] Та нүглээ Бурханаас нууж чадахгүй гэдгээ мэддэг үү?

29.2 Үр удмаа сэргээх

²²ЭЗЭН Бурхан-Үзэгтүн! Энэ хүн одоо сайн мууг мэдэх талаараа бидний нэгэн адил болсон. Тэр одоо гараа сунган, бас амийн модны жимснээс авч идээд, мөнх наслах вий хэмээн айлджээ . (Эхлэл 3:22 АБ 2004)

⁷Ялагч нь эдгээр зүйлийг өвлөх бөгөөд Би түүний Бурхан болж, тэр Миний хүү болно. (Илчлэлт 21:7 АБ 2004)

[] Та өөрийгөө ялах цаг нь одоо гэдгийг та мэддэг үү ?

[] Дуулгаваргүй байдал нь хараал авчирж, хараал нь нүгэл рүү хөтөлж, нүгэл нь үхэл рүү хүргэснийг та мэдэх үү?

29.3 Үхлийг үүрд устгах

¹⁹Чи газар шороондоо эргэж очих хүртлээ Духныхаа хөлсийг дуслуулан байж хоолоо олж иднэ. Учир нь чамайг газар шорооноос авсан. Чи тоос шороо тул тоос шороондоо буцаж очих болно гэжээ. (Эхлэл 3:19 АБ 2004)

¹⁴Тэгээд үхэл ба Үхэгсдийн орон галт нуурт хаягдлаа. Энэ бол хоёр дахь үхэл буюу галт нуур болой. (Илчлэлт 20:14 АБ 2004)

[] Энэ мөчлөг нь үхэх хүртэл үргэлжлэх болно гэдгийг та мэдэх үү?

29.4 Хуучнаас шинэ тэнгэр ба шинэ газар уруу

¹⁷Адамд хандан -Чи эхнэрийнхээ үгийг сонсож, “Бүү ид!” гэж Миний чамд тушаасан модноос идсэн учир Чамаас болж газарт хараал хүрч, Чи насан туршдаа зүтгэж байж ургацыг нь идэх болно. (Эхлэл 3:17 АБ 2004)

[] Та Бурханы дуу хоолойг уу эсвэл хүмүүсийн дуу хоолойг сонсдог уу?

¹Би шинэ тэнгэр, шинэ газрыг харлаа. Учир нь анхны тэнгэр, анхны газар нь өнгөрөн одож, тэнгис байхгүй болов. (Илчлэлт 21:1 АБ 2004)

[] Шинэ тэнгэр шинэ газарт хэн оршин суухыг та мэдэх үү?

29.5 Хүний гараар барьсан сүмээс Бурханы барьсан сүм рүү

²Ариун хот, шинэ Иерусалим нь нөхөртөө очихоор гоёсон сүйт бүсгүй мэт бэлтгэгдэн Бурханаас гарч, тэнгэрээс буун ирэхийг би харлаа. (Илчлэлт 21:2 АБ 2004)

[] Та "Шив шинэ зүйл" ирж байгааг мэдэх үү?

[] Та энэ "ШИНЭ" –д ямар ажил үйлс холбоотойг мэдэх үү?

29.6 ЗҮРХ ӨВДӨЛТӨӨР ДҮҮРСЭН

⁶Өөрөө хүнийг газар дээр бүтээсэндээ харамсан, сэтгэл зүрхэндээ гашуудав.⁷ЭЗЭН -Би тэднийг бүтээсэндээ харамсаж байгаа учир Өөрийн бүтээсэн хүнийг газрын хөрснөөс арчин зайлуулахдаа хүнээс авахуулаад мал адгуус, мөлхөгчид, жигүүртэн шувуудыг ч хүртэл үлдээхгүй гэж хэлэв. (Эхлэл 6:6-7 АБ 2004)

³Сүү, балаар бялхсан нутаг уруу яв. Та нар зөрүүд ард түмэн учраас Би та нарын дунд явахгүй. Эс бөгөөс Би та нарыг замд хөнөөнө гэв. (Египетээс гарсан нь 33:3 АБ 2004)

⁰Тэд цөлд Түүний эсрэг хичнээн их тэрсэлж, Говьд Түүнийг хичнээн их гашуудуулсан бэ! (Дуулал 78:40 АБ 2004)

¹¹-Би Саулыг хаан болгосондоо харамсаж байна. Учир нь тэр Намайг дагахаас буцан эргэж, Миний тушаалыг үл сахив гэв. Самуел санаа зовж, шөнөжингөө ЭЗЭНд хандан уйлав. (1 Самуел 15:11 АБ 2004)

[] Та дуулгаваргүй үедээ Ариун Сүнсийг гашуудахад хүргэдэг гэдгээ мэддэг үү?

[] Үг таньтай ярих үед эсвэл Сүнс таньд сануулж байх үед та дуулгавартай байдаг уу?

[] Бурхан ч бас таньтай адилхан мэдрэмжтэй байдаг гэдгийг та мэдэх үү?

[] Нүглүүд нь бүртгэгдэж, шүүлтийн төлөө зарлан дуудах гарсан гэдгийг та мэдэх үү?

[] Нүглүүд нь Бурхантай хамт байж чадахгүй гэдгийг та мэдэх үү?

[] Та "Таны хаанчлал тэнгэрт шигээ газар дээр ирэх болтугай " гэсний утгыг мэдэх үү ?

29.7 Дуулгаваргүй байдал нь Ариун сүнсийг гомдоодог

¹⁰Харин тэд эсэргүүцэн, Түүний Ариун Сүнсийг гомдоов. Тийм учраас Тэр эргэн, тэдний дайсан болж, тэдний эсрэг Өөрөө дайтсан юм. (Исаиа 63:10 АБ 2004)

³⁰Бурханы Ариун Сүнсийг бүү гомдоо. Золилтын өдрийн төлөө та нар Түүгээр тамгалуулсан билээ. (Эфэс 4:30 АБ 2004)

⁵¹Зөрүүд, зүрх ба чихэндээ хөвч хөндүүлээгүй та нар Ариун Сүнсийг үргэлж эсэргүүцдэг. Та нар эцэг өвгөдийнхөө үйлдсэнийг үйлддэг. (Үйлс 4:30 АБ 2004)

²⁰Мэргэн ухаан нь гудамжнуудад чангаар зарлан дуудаж, Олон хөлийн газар дуугаа өндөрсгөдөг. ²¹Шуугиант гудамжнуудын гол газруудад тэр орилон хашхирдаг бөгөөд Хотын дааман хаалган дээр өөрийнхөө үгсийг хэлдэг юм. ²²“Гэнэн хүмүүс ээ, гэнэн мунхаг байдлаа та нар хир удаан хайрлах вэ? Хэдий хүртэл басамжлагсад доог тохуу хийж, Мунхаг хүмүүс мэдлэгийг үзэн ядах юм бэ? ²³Миний зэмлэлд эргэн ханд. Харагтун, би та нарын дээр сүнсээ бялхуулна, та нарт үгээ мэдүүлнэ. ²⁴Би та нарыг дуудсан, харин та нар үл хэрэгссэн. Гараа сунгахад минь хэн чинь ч анхаарсангүй. ²⁵Та нар бүх зөвлөгөөг минь үл ойшоон, зэмлэлийг минь эс хүссэн. (Сургаалт үгс 1:20-25 АБ 2004)

¹¹Яагаад гэвэл тэд Бурханы үгсийн эсрэг тэрслэн, Хамгийн Дээд Нэгэний зөвлөг өөг үл тоосон. (Дуулал 107:11 АБ 2004)

²Аяа, тэнгэр минь, сонсогтун. Газар минь, чих тавигтун. ЭЗЭН айлдаж байна. “Миний өсгөж, торниулсан хөвгүүд Миний эсрэг бослоо. ³Шар өөрийн эзнээ таньдаг. Илжиг ч эзнийхээ тэвшийг таньдаг. Харин Израиль мэддэггүй. Миний хүмүүс ойлгодоггүй”. (Исаиа 1:2-3 АБ 2004)

[] Та нар бүрэн хайрыг мэдэх үү?

[] Мөргөл нь Бурханы хувьд яагаад хамгийн их нэр хүндтэй үйл явдал болохыг та мэдэх үү?

[] Та Бурханы зүрхийг мэдэрдэг үү?

29.8 Өдөр бүр би та нарт элч нарыг илгээсэн

¹“Гуйгаагүй хүмүүст Би Өөрийгөө илчилж, Намайг эрээгүй хүмүүст Би олдов. Миний нэрийг дуудаагүй үндэстэнд “Би энд байна, Би энд байна” гэж Би айлдав.

²Өөрийн бодлыг дагаж, буруу замаар явагч, бослого гаргагч ард түмэн уруу Би бүхэл өдрийн турш мутраа сунгасан. ³Энэ ард түмэн бол Миний нүүрэн дээр Намайг байнга доромжлон, цэцэрлэгт тахил өргөн, тоосгон дээр үнэртнийг шатааж, ⁴булшнуудын дунд сууж, нууц газруудад шөнийг өнгөрөөн, гахайн мах идэн, савандаа бузар махны шөлийг хийдэг бөгөөд, ⁵“Зогс. Над уруу бүү ойртогтун. Учир нь би чамаас илүү ариун” гэж хэлдэг.

Тэд бол Миний хамарт үнэртэх утаа, бүх л өдөржин шатдаг гал юм. ⁶“Үзэгтүн, энэ нь Миний өмнө бичигдсэн. Би дуугүй байхгүй, харин буцааж төлнө. Түүгээр ч үл барам Би тэдний өвөрт нь төлнө. ⁷Ингэхдээ та нарын хилэнц хийгээд та нарын эцэг өвгөдийн хилэнцийг хоёуланг нь хамтад нь төлнө” гэж ЭЗЭН айлдаж байна. (Исаиа 65:1-7 АБ 2004)

¹³Эдүгээ та нар эдгээр бүх зүйлсийг үйлдсэн тул” гэж ЭЗЭН ингэж тунхаглаж байна, “Мөн эрт босож ярин Би та нарт хэлсэн боловч та нар сонсоогүй, Би та нарыг дуудсан боловч та нар хариулаагүй тул, (Иеримиа 7:13 АБ 2004)

²⁵Та нарын эцэг өвгөд Египетийн нутгаас гарч ирсэн тэр өдрөөс хойш өнөөг хүртэл Би та нарт Өөрийн бүх зарц нар болох эш үзүүлэгчдийг илгээн, өдөр бүр эрт босож илгээсэн билээ. (Иеримиа 7:25 АБ 2004)

²⁰Мэргэн ухаан нь гудамжнуудад чангаар зарлан дуудаж, Олон хөлийн газар дуугаа өндөрсгөдөг. ²¹Шуугиант гудамжнуудын гол газруудад тэр орилон хашхирдаг бөгөөд Хотын дааман хаалган дээр өөрийнхөө үгсийг хэлдэг юм. ²²“Гэнэн хүмүүс ээ, гэнэн мунхаг байдлаа та нар хир удаан хайрлах вэ? Хэдий хүртэл басамжлагсад доог тохуу

хийж,Мунхаг хүмүүс мэдлэгийг үзэн ядах юм бэ? ²³Миний зэмлэлд эргэн ханд.Харагтун, би та нарын дээр сүнсээ бялхуулна, та нарт үгээ мэдүүлнэ. (Сургаалт үгс 1:20-23 АБ 2004)

¹¹Учир нь бүс хүний бэлхүүст наалддаг шиг, Би Израилийн бүхэл гэрийг болон Иудагийн бүхэл гэрийг Өөртөө наалдуулсан нь тэд Миний хувьд нэр хүнд, магтаал, алдрын төлөөх хүмүүс байхын тулд юм. Гэвч тэд сонсоогүй” гэж ЭЗЭН тунхаглаж байна. (Иеримиа 13:11 АБ 2004)

[] Түүний үгээр наманчлах нь Түүний оршихуйг урьдаг гэдгийг та мэдэх үү?

[] Дуулгаваргүй байдал нь Түүнийг эсэргүүцэж Түүний дайсантай хуйвалдсан гэдгийг та мэдэх үү?

[] Исаиа 65-д «Өдөржин» гэдэг үг ямар утгатайг та мэдэх үү?

29.9 Намайг хүндлэхүй нь хаана байна?

³³Тэд нүүрээ бус, нуруугаа Над уруу харуулав. Хэдийгээр тэдэнд дахин, дахин заан сургасан боловч, тэд үл сонсож, зааврыг хүлээн авахгүй байв. (Иеримиа 32:33 АБ 2004)

⁶“Миний нэрийг жигшигч тахилч нар аа, “Хүү нь эцгээ, зарц нь эзнээ хүндэтгэдэг. Би эцэг юм бол Намайг хүндэтгэх нь хаана байна вэ? Би эзэн юм бол Намайг хүндэтгэх нь хаана байна вэ?” гэж түмэн цэргийн ЭЗЭН та нарт айлдаж байна. Гэвч та нар “Бид Таны нэрийг яаж жигшсэн бэ?” гэж асуудаг. (Малахи 1:6 АБ 2004)

¹³Зохисгүй өргөлөө цаашид бүү авчрагтун. Утлага чинь Надад жигшүүртэй байна. Шинэ сар, амралтын өдөр, цугларалтын дуудлага болох бузар гэм болон ёслолын чуулганыг Би тэвчиж чадахгүй. ¹⁴Та нарын шинэ сарын баяр, тогтоосон найруудыг Би үзэн ядаж байна. Тэдгээр нь Надад дарамт болж, тэднийг үүрснээс болж Би ядарч байна. (Иеримиа 1:13-14 АБ 2004)

¹⁸“Нааш ир. Хамт хэлэлцье” гэж ЭЗЭН айлдаж байна. “Та нарын нүглүүд час улаан мэт боловч цас шиг цагаан болно. Тэдгээр нь хүрэн улаан боловч ноос шиг болох болно. (Исаиа 1:18 АБ 2004)

¹⁰“Миний тахилын ширээн дээр ашиггүй галыг асаахгүйн тулд та нарын дундаас хэн нэгэн нь хаалгуудыг хаагаасай! Би та нарт таагүй байна. Та нарын гараас Би өргөлийг чинь хүлээн авахгүй” гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна. (Малахи 1:10 АБ 2004)

⁴Гэсэн хэдий ч Би та нарт эш үзүүлэгчид болох Өөрийн бүх зарц нарыг дахин дахин илгээж, “Миний үзэн яддаг энэ жигшүүрт зүйлийг бүү хийгээч” гэж хэлүүлсэн. (Иеримиа 44:4 АБ 2004)

29.10 Гэсэн хэдий ч, одоо ч хүртэл Түүний хайр хэвээрээ

²⁰Тэгээд тэр босож, эцэг уруугаа явжээ. Харин эцэг нь түүнийг холоос хараад, ихэд өрөвдөн гүйн ирж, тэврээд үнсэв. ²¹Хүү нь түүнд “Аав аа, би тэнгэрийн эсрэг, таны өмнө нүгэл үйлджээ. Би цаашид таны хүү гэгдэх нь зохисгүй” гэв. ²²Харин эцэг нь боолууддаа “Хамгийн сайхан хувцас хурдан авчирч, түүнийг хувцасла. Гарт нь бөгж зүү, хөлд нь гутал өмсгө. ²³Тарган тугал авчирч гарга. Бүгдээрээ найрлаж цэнгэе. ²⁴Учир нь энэ хүү маань үхсэн байсан юм. Гэвч амилжээ. Тэр алдагдсан ч олдлоо” гэв. Тэд найрлан цэнгэлдэж эхлэв. (Лук 15:20-24 АБ 2004)

²⁰Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дууг сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно. (Илчлэлт 3:20 АБ 2004)

⁵Сэнтийд Залрагч -Харагтун, Би бүх юмсыг шинэ болгож байна гээд -Бичигтүн, эдгээр үгс итгэмжит бөгөөд үнэн гэв. ⁶Тэр надад -Биеллээ. Би бол Альфа ба Омега, Эхлэл ба Төгсгөл. Цангасан нэгэнд Би амийн усны булгаас үнэгүй

өгнө. ⁷Ялагч нь эдгээр зүйлийг өвлөх бөгөөд Би түүний Бурхан болж, тэр Миний хүү болно. (Илчлэлт 21:5-7 АБ 2004)

[] Самуун явдлын төгсгөл хаана болохыг та мэдэх үү?

[] Тэрслүү нэгнүүдийн гэмшиж буаж ирэхгүй бол тэдэнд тохиолдох зүйлийн улмаас та гашуудаж байна уу?

[] Эцэг нь хэрхэн хүүгээ холоос таньж чадсаныг та мэдэх үү?

[] Та Их Эзэний Сүнсний хэлж байгааг сонсдог уу?

[] Эцэг яагаад аливааг өөрөөр хийдгийг та мэдэх үү?

[] Дэлхийн, шуналт, чөтгөрийн: эдгээр нь Эзэний үйлсийн эсрэг билээ. Та эдгээрээс аль нэгийг амьдралдаа харж байна уу?